



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
1094 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
10.6%



НИЙТ ХАДГАЛАМЖ
14.4 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
30.6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
847.7 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
10%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **+6.1%**
Инфляци: 2020 онд: **7.5%**

Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **+6.3%**
Инфляци: 2020 онд: **+7.1%**,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.8%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 3-р сарын байдлаар 276 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 192.5 хувиар, зарлага 187.7 хувиар тус тус нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 160 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 12.5 төгрөгөөр өсөв.

Гуравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 136 төгрөг буюу 5.2 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 12.5 төгрөг буюу 0.4 хувиар, өмнөх улирлаас 1.5 хувиар өсч 2769.03 төгрөг болов. 3-р сард гадаад валютын нөөц 1.0 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 6.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөн бол, оны эхнээс 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 6.4%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 3-р сарын байдлаар өмнөх сараас 0.7 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар, оны эхнээс 2.9 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний өссөн нь голлон нөлөөлжээ.




Гадаад худалдааны тэнцэл 125.8 сая.ам доллар болов.

2020 оны гуравдугаар сард нийт барааны эргэлт 2197 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 28.1 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 41.5, импорт өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 125.8 сая ам.долларын алдагдалтай гарав.



3-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ



Эх сурвалж: www.1212.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3-р сард өмнөх сараас 1.2 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 1.7 хувиар буурч 17.1 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1833 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.5 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 1.7 хувиар тус тус буурав. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 10.6% байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 120.0 (11.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 236.6 (25.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр өссөн байна. Иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдлийн 40.4 хувийг ипотекийн зээл, 26.6 хувийг цалингийн зээл, 14.7 хувийг жижиг дунд үйлдвэрийн зээл, 11.6 хувийг хэрэглээний зээл, 1.1 хувийг тэтгэврийн зээл, 5.6 хувийг бусад зээл тус тус эзэлж байна. Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 75.2 хувийг арилжааны банкуудаас олгосон зээл байна.

САРЫН ОНЦЛОХ

БОДЛОГЫН ХҮҮ 10 ХУВЬ БОЛОВ.

- Монголбанкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэв. Түүнчлэн банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг хоёр нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөхөөр шийдвэрлэв. Энэ шийдвэр нь инфляцийн зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэж байна. Түүнчлэн коронавирусын тархалттай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж байгаагаас гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурч, гадаад болон дотоод эдийн засгийн идэвхжил сулран, эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах эрсдэлийг бий болгож байна. Экспортын орлого буурах эрсдэл нэмэгдэж байгаа хэдий ч хэрэглээний импорт агших хандлага үргэлжилж, дэлхийн зах зээл дээр нефтийн үнэ огцом буурсан нь төгрөгийн ханшид үзүүлэх дарамтыг зөөлрүүлэх төлөвтэй.

ГАДААД ХУДАЛДАА ЭХНИЙ САРУУДАД

- Манай улс оны эхний хоёр сард 770.3 сая ам.долларын экспорт, 750 сая ам.долларын импорт хийжээ. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад экспорт 29 хувиар, импорт 10 хувиар буурчээ. Экспорт буурахад Гашуунсүхайд, Шивээхүрэн боомтоор нүүрсний экспортыг зогсоосон нь голлон нөөлөөлжээ. Тухайлбал, чулуун нүүрсний экспорт өмнөх оныхоос 1.2 сая тн, зэсийн баяжмал 37 мянган тн, боловсруулаагүй нефть 723 мянган баррелиар буурч, төмрийн хүдэр, цайрын хүдрийн баяжмалын экспорт бага зэрэг нэмэгдсэн байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 3-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 3-р сар 2020 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn